БАТЛАВ.
ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
АА-НЫ ДАРГА

Б.БОЛОР-ЭРДЭНЭ

БАТЛАВ.
БОУАӨЯ-ны ОЗОНЫ ҮНДЭСНИЙ АЛБАНЫ
ЗАХИРАЛ

Ц.АДЬЯАСҮРЭН

АЖЛЫН ДААЛГАВАР

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭР:

Хөргөлт, агааржуулалтын (RAC) засвар үйлчилгээний салбарын ахуйн болон үйлчилгээний байгууллагын хөргөлт, агааржуулалт, дулааны насосын төхөөрөмжид эрчим хүчний гүйцэтгэлийн хамгийн бага стандарт (цаашид MEPS гэх)-ыг боловсруулах, түүнийг нэвтрүүлэх.

ОРШИЛ:

Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас эрчим хүч хэмнэлтийн бодлогыг тодорхойлж, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийг 2015 онд баталсан. Эрчим хүч хэмнэлтийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд эрчим хүчний үр ашигтай, дэвшилтэт машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан барааны хэрэглээг нэмэгдүүлэх замаар эрчим хүчийг хэмнэх, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах нь энэхүү бодлогын нэгэн гол чиглэл юм. Энэ ажлыг хэрэгжүүлэхэд эрчим хүчний үр ашигтай цахилгаан барааны хэрэглээг нэмэгдүүлэх, зах зээлийг хөгжүүлэх, хэрэгжүүлэх механизм, эрх зүйн тогтолцоог улам боловсронгуй болгохыг шаардаж байна.

Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9.г -д заасны дагуу “Эрчим хүчний хэрэглээний ангилал, зэрэглэл тогтоох, шошгожуулах, хяналт тавих журам”-ыг боловсруулж, хэрэгжүүлэх талаар заасан байдаг. Энэхүү эрх зүйн зохицуулалтыг хангах, суурь нөхцөлийг бий болгох Хөргөлт, агааржуулалтын (RAC) засвар үйлчилгээний салбарын хүрээнд ахуйн болон үйлчилгээний байгууллагын хөргөлт, агааржуулалт, дулааны насосын тоног төхөөрөмжид тусгайлан MEPS-ыг боловсруулж, нэвтрүүлэх, эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, холбогдох судалгааны ажлыг хийх зорилгоор зөвлөхийн ажлын даалгаврыг боловсруулав.

ЗОРИЛГО:

Монгол Улсад эрчим хүчний үр ашигтай, дэвшилтэт машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан барааны хэрэглээг нэмэгдүүлэх, энэ төрлийн бизнес эрхлэх зах зээлийн механизмыг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, холбогдох стандарт зохицуулалтын суурь нөхцөлийг бий болгох зорилготой.

Энэхүү зорилгын хүрээнд Хөргөлт, агааржуулалтын (RAC) засвар үйлчилгээний салбарын ахуйн болон үйлчилгээний байгууллагын хөргөлт, агааржуулалт, дулааны насосын тоног төхөөрөмжид эрчим хүчний хэрэглээний шошго болон MEPS-ыг бий болгох, нэвтрүүлэх, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, холбогдох судалгааны ажлыг хийх, энэ тухай үндсэн ойлголт, холбогдох техникийн зохицуулалтыг боловсруулах, эрчим хүчний үр ашигтай, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар багатай (ДДНЧ/GWP) хөргөх бодис бүхий дэвшилтэт технологи машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний хөргөлт, агааржуулалт, дулааны насосыг хил гаалиар оруулах, худалдан борлуулагч, хэрэглэгчдэд мэдээлэл өгч чадавхжуулах, бизнесийн загварыг тодорхойлох ажлыг хийж гүйцэтгэнэ.

АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ:

Хөргөлт, агааржуулалтын (RAC) засвар үйлчилгээний салбарын ахуйн болон үйлчилгээний байгууллагын хөргөлт, агааржуулалт, дулааны насосын тоног төхөөрөмжийн эрчим хүчний хэмнэлтийг шошгожуулах үйл ажиллагааг бэхжүүлэх болон MEPS-ыг боловсруулах, түүнийг нэвтрүүлэхэд холбогдох бодлогын баримт бичгүүдийг боловсруулах (Төслийн 6.2 дугаар бүрэлдэхүүн), мэдлэг, мэдээлэл түгээх (Төслийн 7.1, 7.2 дугаар бүрэлдэхүүн) төслийг хэрэгжүүлнэ. Боловсруулсан төсөл тус бүрийг захиалагч тал болон бусад хамтрагч талаас санал авах, авсан санал зөвлөмжийн дагуу төслүүдийг дахин боловсруулж хүргүүлнэ.

1. Шошго болон MEPS-ыг боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх

Монгол Улсад эрчим хүчний хэрэглээний шошго болон MEPS-ыг бий болгох эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, тус үйл ажиллагааг явуулахад шаардлагатай хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор нэмэлт, өөрчлөлт оруулах, шинээр батлах эрх зүйн баримт бичгийн санал боловсруулна. Дэвшүүлж буй санал нь эрчим хүчний хэрэглээний шошго болон MEPS-ыг бий болгох тэдгээртэй холбогдсон харилцаа, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх баримт бичгийн төсөл байх ба тус үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зохицуулалтын баримт бичгийн төслүүдээс бүрдэнэ.

1.1. Монгол Улсын Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль, түүний хэрэгжилт, эрчим хүчний хэмнэлттэй хөргөлт, агааржуулалт, дулааны насосын тоног төхөөрөмжийг шошгожуулах үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, зөвлөмж гаргана.

1.2. Хөргөлт, агааржуулалтын (RAC) засвар үйлчилгээний салбарын ахуйн болон үйлчилгээний байгууллагын хөргөлт, агааржуулалт, дулааны насосын тоног төхөөрөмжийн эрчим хүчний хэмнэлтийн шошготой холбоотой журмын төсөл боловсруулна. Шошгожуулах ажлыг бэхжүүлэх, үр дүнтэй болгох талаар зөвлөмж боловсруулж, шийдвэр гаргагчдад зөвлөмж өгнө.

1.3. Хөргөлт, агааржуулалтын (RAC) засвар үйлчилгээний салбарын Ахуйн болон үйлчилгээний байгууллагын хөргөлт, агааржуулалт, дулааны насосынтоног төхөөрөмж тус бүрээр тусгайлсан MEPS-ыг бий болгож, зохицуулалтын баримт бичгийн төслийг боловсруулж, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулна. MEPS-ын зохицуулалтын баримт бичгийн төсөл нь Эрчим хүч хэмнэлтийн тухай хууль болон эрчим хүчний хэрэглээний шошготой холбоотой журмын төсөлтэй уялдаж, оролцогч талуудын эрх ашгийг тэнцүү хамгаалсан, мэргэжлийн үйлчилгээ, үйл ажиллагаатай холбоотой суурь зарчмуудыг тусгасан, холбогдох талуудын эрх, үүрэг, хариуцлага, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

1.4. Өнөөгийн хууль эрх зүйн орчин түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, олон улсын шилдэг туршлагаас судалж эрчим хүч хэмнэлттэй тоног төхөөрөмжийг шошгожуулах үйл ажиллагаа болон MEPS-ыг нэвтрүүлэх судалгааны ажил хийнэ. MEPS зохицуулалтын баримт бичгийг нэвтрүүлж, хэрэгжүүлэх загвар боловсруулна.

2. Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалт

Хөргөлт, агааржуулалтын (RAC) засвар үйлчилгээний салбарын ахуйн болон үйлчилгээний байгууллагын хөргөлт, агааржуулалт, дулааны насосын тоног төхөөрөмжийн озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодисын байгаль орчны хүчин зүйлсийг эрчим хүчний хэмнэлтийн зохицуулалтын энэхүү ажлын даалгаврын 1-д тусгагдсан журамд тусгана. Мөн дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (GWP) багатай орлуулах хөргөх бодист суурилсан тоног төхөөрөмжөөс эрчим хүч хэмнэхтэй холбоотой хууль эрх зүйн орчны харьцуулсан дүн шинжилгээ хийж, озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах

бодисуудын зохицуулалт болоод гаалийн байгууллагаас MEPS-ын механизмыг хэрэгжүүлэх аргачлалын талаарх зөвлөмж боловсруулна.

2.1. Стандарт зохицуулалтын баримт бичгийг боловсруулахдаа Монгол Улсын зах зээлд одоо байгаа хөргөлт, агааржуулалт, дулааны насос (RACHP)-ын тоног төхөөрөмжийн хамгийн сүүлд шинэчлэгдсэн статистик мэдээг үндэслэн хамгийн өргөн хэрэглээтэй тоног төхөөрөмжүүдэд зориулан боловсруулна.

2.2. Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (GWP) багатай хөргөх бодис агуулсан тоног төхөөрөмжийг импортоор оруулахад олгох урамшууллын талаар судалж, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулна.

2.3. Оролцогч талууд болон шийдвэр гаргагчдад зориулж дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (GWP) багатай хөргөх бодис агуулсан цахилгаан хэрэгслийн талаарх мэдээллийн санг үүсгэж холбогдох байгууллагын цахим системд нийтлэх боломжийн талаар судалж зөвлөмж боловсруулна.

2.4. Дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (GWP) ихтэй хөргөх бодисыг дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар (GWP) багатай хөргөх бодистой харьцуулж байгаль орчинд үзүүлэх нөлөө, зардал хэмнэлт, ашиг тусыг харуулах зорилгоор импортлогчдод зориулсан мэдээллийн санг үүсгэж холбогдох байгууллагын цахим системд нийтлэх боломжийн талаар судалж зөвлөмж боловсруулна.

3. Эрчим хүчний гүйцэтгэлийн хамгийн бага стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх стратеги боловсруулах

3.1. Монгол Улсад хөргөлт, агааржуулалт, дулааны насос (RACHP)-ын тоног төхөөрөмжийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын мэдээллийн санг үүсгэнэ.

3.2. Стандарт зохицуулалтын баримт бичгийг нэвтрүүлсэнтэй уялдуулан үүсэх эрсдэлийн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулна. Тус ажлыг хэрэгжүүлэхэд тулгарч болох эрсдэлийн шинжилгээ хийх, суурь шугамыг тодорхойлоход гарч болох эрсдэл, борлуулалтын мөчлөгийн эрсдэл, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн үеийн эрсдэлүүдийг тооцох талаар зөвлөмж боловсруулна.

3.3. Судалгааны ажлын үр дүнг хууль, эрх зүйд нийцүүлэн холбогдох эрх зүйн баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулна.

3.4. Озоны үндэсний алба болон Эрчим хүчний зохицуулах хороотой хамтран ажлын уулзалтууд зохион байгуулж, уулзалтуудаас гарсан үр дүнг оролцогч талууд болон шийдвэр гаргагчдад танилцуулах семинарыг зохион байгуулна. Зохион байгуулсан семинарын тайланг бэлтгэж ирүүлнэ.

3.5. Боловсруулсан стандарт зохицуулалтын баримт бичиг нийцсэн хөргөлт, агааржуулалт, дулааны насос (RACHP)-ын тоног төхөөрөмжийг хил, гаалиар нэвтрүүлэхэд хяналт шалгалт, баталгаажуулалтыг хэрхэн хийх талаар холбогдох байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр зөвлөмж аргачлалыг боловсруулна.

4. Эдийн засгийн дүн шинжилгээ, эрчим хүч хэмнэлтийн болон ашиглалтын хугацааны зардлыг харьцуулсан судалгаа

Хөргөлт, агааржуулалтын (RAC) засвар үйлчилгээний салбарын ахуйн болон үйлчилгээний байгууллагын хөргөлт, агааржуулалт, дулааны насосын төхөөрөмжид MEPS-ын эдийн засгийн дүн шинжилгээ, эрчим хүч хэмнэлтийн болон ашиглалтын хугацааны зардлыг харьцуулсан судалгаа, мэдлэг, мэдээлэл түгээх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулна.

4.1. GWP багатай хөргөх бодис бүхий тоног төхөөрөмжийн эрчим хүчний хэмнэлтийн судалгаа, эдийн засгийн дүн шинжилгээ хийнэ.

- Монгол Улсад импортоор оруулж ирж буй ДДНЧ/GWP багатай хөргөх бодис бүхий тоног төхөөрөмжийн эдийн засгийн дүн шинжилгээ, эрчим хүч хэмнэлтийн болон ашиглалтын хугацааны зардлыг харьцуулсан судалгааны тайлан боловсруулна. Тухайн тайланд Монгол Улсын зах зээлд одоо байгаа хөргөлт, агааржуулалт, дулааны насос (RACHP)-ын тоног төхөөрөмжийн хамгийн сүүлд шинэчлэгдсэн статистик мэдээг оруулах;
- Эдийн засгийн үр ашиг /зардлын үр нөлөө/ эрчим хүчний хэмнэлтийг харуулах 1-2 инфографик боловсруулсан байх;
- GWP ихтэй хөргөх бодисыг GWP багатай хөргөх бодистой харьцуулж байгаль орчинд үзүүлэх нөлөө, зардал хэмнэлт, ашиг тусыг харуулах зорилгоор импортлогчдод зориулсан маркетингийн материал боловсруулах;

4.2. Тоног төхөөрөмж импортлогчид, жижиглэн худалдаалагчдад зориулан Монгол Улсад худалдаалагдсан эрчим хүчний хэмнэлт өндөртэй, GWP багатай хөргөх бодис бүхий тоног төхөөрөмжийн талаар сурталчлах, тэдгээрийн ашиг тусыг харуулах 2-3 удаагийн мэдлэг, мэдээлэл түгээх сургалт зохион байгуулна.

ХҮРЭХ ҮР ДҮН БОЛОН ТАЙЛАН

Ажлын даалгаврын 1-ээс 4-д тусгагдсан ажлуудын үр дүнд эрх зүйн орчныг бүрдүүлсэн, MEPS боловсруулсан, озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодистой холбоотой эрх зүйн зохицуулалт хийгдсэн, тэдгээрийг нэвтрүүлж хэрэгжүүлэх стратеги боловсруулагдсан, мэдлэг мэдээлэл түгээгдсэн байх ба дараах тайлангууд гарч, холбогдох баталгаажуулалт хийгдсэн байна. Үүнд:

I. Шошго болон MEPS-ыг боловсруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбоотой хийгдсэн ажлын тайлан;
II. Хөргөх бодис агуулсан төхөөрөмжүүдийн талаарх тайлан/судалгааны гол үр дүн, шинжилгээ, ололтуудыг шийдвэр гаргагчид болон оролцогч талуудад хүргэх Мэдээллийн тэмдэглэл (information note)
III. Озон задалдаг, дэлхийн дулааралд нөлөөлөх чадвар өндөртэй бодис болон бусад орлуулах бодис, түүнтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын талаар хийгдсэн ажлын тайлан;
IV. Эрчим хүчний гүйцэтгэлийн хамгийн бага стандартыг нэвтрүүлж, хэрэгжүүлэх стратеги боловсруулахтай холбоотой хийгдсэн ажлын тайлан;
V. Эдийн засгийн дүн шинжилгээ, эрчим хүч хэмнэлтийн болон ашиглалтын хугацааны зардлыг харьцуулсан судалгааны тайлан;
VI. Тоног төхөөрөмж импортлогч, жижиглэн худалдаалагчдад зориулан мэдлэг, мэдээлэл түгээх 2-3 сургалт зохион байгуулсан тайлан.

Дээрх тайлангууд Монгол, Англи хэл дээр боловсруулагдсан байх ба Монгол хэлийг үндсэн хэл болгоно.

4.3. Озоны үндэсний алба болон Эрчим хүчний зохицуулах хороо, ажлын хэсэгт ажлын явцын тайланг анхан, дунд, эцсийн гэсэн 3 үе шаттай танилцуулж, монгол, англи хэлээр хүлээлгэн өгнө. Ажлын үр дүнг тухай бүр нь танилцуулах, ажлын уулзалтуудыг зохион байгуулж, уулзалтуудаас гарсан үр дүнг дээрх тайлангуудад тусгах ба бусад оролцогч талууд болон шийдвэр гаргагчдад танилцуулах семинарыг зохион байгуулна. Зохион байгуулсан семинарын тайланг бэлтгэж ирүүлнэ.

ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

12 сарын хугацаанд гүйцэтгэнэ.

---oOo---